

**СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ  
ХОЛБООТОЙ НЭР ДЭВШИГЧ, УЛС  
ТӨРИЙН НАМ, ЭВСЛҮҮДЭД ӨГӨХ  
ЗӨВЛӨМЖ, САНАМЖ**

## **СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ НЭР ДЭВШИГЧ, УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЛҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ, САНАМЖ**

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулагдаж буйтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссоос нэр дэвшигч, улс төрийн нам, эвслүүдэд сонгуулийн сурталчилгааг хийхдээ хүний эрхийн зарчим, хэм хэмжээг баримталж ажиллах талаар зөвлөмж, санамж боловсруулан хүргүүлж байна.

Сонгуульд нэр дэвших, сонгуулийн сурталчилгаа хийхтэй холбоотой зарим хууль тогтоомжийн зохицуулалтаас...

“Улс төрийн нам нь сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.”

***(Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалт)***

“...сонгуульд оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгууль зохион байгуулах, түүнд оролцохдоо хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих зарчмыг баримтална.”

***(Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг)***

“Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

***(Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлийн 14.8.1 дэх заалт)***

“Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн; нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан,

тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн; сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулсан, амралт, сувилалд амраасан, сувилуулсан; ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн; хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр бусдад давуу байдал олгосон, амлалт өгсөн; сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан; харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

***(Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.16.1 дэх заалт)***

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬТАЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАЖ БҮЙ ЗӨВЛӨМЖ

Дэлхийн 70 гаруй улс 2024 онд ардчилсан тогтолцооны ирээдүйд тодорхойлоход онцгой ач холбогдолтой сонгуулийг зохион явуулж байна. Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээд байна. Энэ удаагийн сонгууль Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу сонгуулийн холимог тогтолцоо, тойргийн шинэ хуваарилалтаа зохион байгуулагдахаас гадна олон нийтийн сүлжээ, цахим технологи, хиймэл оюун ухааныг сонгуулийн сурталчилгаа, зохион байгуулалтад түгээмэл ашиглаж байгаагаараа онцлогтой. Сонгуулийн тогтолцооны шинэ тутам байдал, олон улсын болон дотоодын улс төрийн сорилт бүхий өнөөгийн нөхцөлд 2024 оны УИХ-ын сонгуулийг шударга, чөлөөтэй, ил тод, хариуцлагатай явуулах нь хүний эрх, эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих үндэсний байгууллагын хувьд дараах асуудлуудыг сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг хуулиар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага болон үйл явцад идэвхтэй оролцох төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, улс төрийн намууд, нэр дэвшигч, олон нийтэд анхааруулан **ЗӨВЛӨЖ** байна.

## **Нэг. Сонгуулийн ил тод байдлыг хангах**

Санал гаргахаас бусад сонгуулийн үйл явц ил тод байх нь олон нийтийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх, үл ойлголцол, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх суурь нөхцөл тул:

1.1 Сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн санал авах өдрөөс өмнө нягтлан шалгаж, давхардал, зөрчлийг арилгах, “түр хасав” нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн иргэний нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн шалтгаан арилсан тохиолдолд тухайн сонгогчийн бүртгэлийг сэргээн сонгох эрхийг эдлүүлэх;

1.2 Сонгуулийн ажиглагчид чиг үүргээ ялгаварлалгүй, зохих ёсоор хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар

санал өгөх сонгогчийн нэрийн жагсаалт, зохион байгуулалтын талаарх мэдээллийг урьдчилан өгч, зөөврийн хайрцгаар санал хураахад ажиглалт хийх боломжийг бүрдүүлэх;

1.3 Санал хураах төхөөрөмжийн ажиллах горим, санал хураалтын үнэн зөв байдлыг хянах механизмын талаарх мэдээлэл, сурталчилгааг өргөн хүрээтэй явуулах;

1.4 Саналын хуудсыг гар аргаар тоолох хяналтын тооллогын үйл явцыг ил тод, хараат бус, ажиглагчид хянах боломжоор хангаж, үйл явцыг шууд дамжуулалтаар олон нийтэд мэдээлэх;

1.5 Сонгуулийн хэсгийн хороод санал авах цаг дуусах хүртэл хууль тогтоомжид заасан зарчим, зохион байгуулалтыг ягштал баримтлан ажиллах;

### **Хоёр. Сонгуулийн оролцоог хангах, сонгогчийг ялгаварлах гадуурхахгүй байх**

Саад бэрхшээлгүй, чөлөөтэй саналаа өгөх боломжийг сонгогч бүрд бүрдүүлэх нь төрийн үүрэг, иргэний үндсэн эрх, засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим тул:

2.1 Санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд тохиромжтой байдлаар бэлтгэх, энэ талаарх стандартыг чанд мөрдөх, санал авах байрыг барилгын хоёр болон түүнээс дээш давхарт, эсхүл подвал байршуулах, өндөр довжоотой, орц гарц хүртээмжгүй, санал авах байрны мэдээлэл, тэмдэглэгээ ойлгомжгүй байх зөрчлийг давтахгүй байх;

2.2 Харааны бэрхшээлтэй иргэдэд санал авах байранд чөлөөтэй зорчих, саналаа нууцаар гаргах нөхцөлийг хангах, санал гаргах талаарх зааварчилгааг сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст ойлгомжтой хүргэх;

2.3 Саналын хуудсыг бөглөх, санал тоолох машинд уншуулах туршилт, мэдээлэл, сурталчилгааг хүртээмжтэй явуулж, саажилттай, харааны бэрхшээлтэй, өндөр настай зэрэг саналын хуудаст бүтэн тэмдэглэгээ хийх боломж хязгаарлагдмал иргэдийн санал гээгдэхгүй байх төхөөрөмжийн тохиргоог бүрдүүлэх;

## **Гурав. Хүсэл зориг, үзэл бодлын чөлөөт илэрхийллийг сахин хамгаалах**

Сонгууль бүхэлдээ төрийн эрх барих байгууллагын төлөөллийг сонгох ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, сонгуулийн үеэр улс төрч, намууд, Засгийн газрын үйл ажиллагааг шүүмжлэх, тайван жагсаал, цуглаан зохион явуулах нь ардчилсан улсад ердийн үйл явц гэдгийг хүлээн зөвшөөрч:

3.1 Үндэсний эв нэгдлийг бусниулах, хүчирхийлэлд уриалаагүй, бусдын нэр төрийг гутаах зорилгоор худал мэдээлэл түгээхээс бусад хэлбэрээр улс төрч, улс төрийн нам, Засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилсэн хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх, ил, далд хэлбэрээр сануулах, биеэр болон харилцаа холбооны хэрэгслээр сүрдүүлэх, дарамтлах, хүсэл зоригийг мохоох аливаа үйлдэл гаргахгүй байх; Иргэн хууль ёсны үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлснийхээ улмаас бусдын дарамт, халдлагад өртөхөөс хамгаалах арга хэрэгслийг идэвхжүүлэх;

3.2 Тайван жагсаал, цуглаанд оролцогчдыг Цагдаагийн байгууллага хамгаалах, эсрэг шаардлага бүхий цуглааныг зохицуулах туршилт, дадлага явуулж, зохицуулах хэмжээний бэлтгэл хангах;

### **Дөрөв. Үзэн ядалт, хүчирхийлэлд уриалсан илэрхийлэл, хүний нэр төр, эрхэм чанарыг гутаах зорилготой худал мэдээлэлтэй тэмцэх**

Хоруу болон ташаа мэдээлэл нь сонгуулийн үед хүний нэр төр, аюулгүй байдалд заналхийлж, нийгмийг талцуулж, хүчирхийллийг өдөөж болзошгүй, энэ эрсдэлийг цахим технологи, хиймэл оюуны ухааны хөгжил, олон нийтийн сүлжээ хурдасгаж, хурцатгах боломжтой тул:

4.1 Улс төрч, улс төрийн хүчнүүд үзэл ядалт, хүчирхийлэлд уриалахгүй, бусдын нэр төрийг гутаах зорилготой худал мэдээлэл тараахгүй, эмэгтэй улс төрчийг хүйсийн хувьд гутаан доромжлохгүйгээр шударга, хүнлэг байх, улс төрийн ардчилсан өрсөлдөөнд бусдад хүндэтгэлтэй оролцох;

4.2 Хиймэл оюун ухаан, олон нийтийн сүлжээ ашиглан үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд уриалсан илэрхийлэл, хүний нэр төр, эрхэм чанарыг гутаах зорилготой худал мэдээлэл бүхий контент

бүтээхэд сонгуулийн сурталчилгаа явуулж байгаа, технологи хөгжүүлж байгаа хүн, хуулийн этгээд оролцохгүй байх, ийм мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийт цахим болон биет орчинд түгээхгүй байх;

4.3 Мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах, бусдын нэр төрийг гутаах зорилготой худал мэдээллийг санаатай тараасан гэмт үйлдлийг таслан зогсоох, мөрдөн шалгах, мэдээллийн тархалтыг хязгаарлах чиг үүрэгтэй албан үйл ажиллагааг идэвхжүүлэх, албан бус хяналтын тогтолцоог дэмжих, албан болон албан бус хяналтын тогтолцооны хамтын ажиллагааг хөгжүүлэх;

### **Тав. Хүний хувийн мэдээллийг хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах**

Хүний хувийн мэдээллийг хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах нь цахим эрин үеийн сонгуулийг шударга явуулах үндэс тул:

5.1 Хүний хувийн мэдээллийг хамгаалж, иргэдийн регистрийн дугаар, гэрийн хаяг, холбоо барих мэдээллийг хуулиар эрх олгогдоогүй этгээд ашиглах, боловсруулах, сонгогчдыг эд мөнгө, бусад амлалтаар татах зэрэг хууль бус үйлдэлд ашиглахгүй байх баталгааг бүрдүүлэх, зөрчлийг нэн даруй таслан зогсоох механизмыг идэвхжүүлэх, олон нийтэд сурталчлах;

5.2 Сонгуулийн дэд бүтцийг хамгаалах кибер аюулгүй байдлын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах;

### **Зургаа. Зөрчил, маргааныг шуурхай шийдвэрлэх**

Сонгуулийн үед зөрчил, маргаан шийдвэрлэх чиг үүрэгтэй байгууллагууд шуурхай, баримтад үндэслэн шийдвэр гаргах, шийдвэрийнхээ үндэслэлийг маргалдагч талууд, олон нийтэд ил тод, ойлгомжтой тайлбарлаж ажиллах нь сонгуулиас улбаатай сөргөлдөөн, хүчирхийлэл, хурцадмал байдлаас сэргийлэх үндсэн арга тул:

6.1 Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, харьяаллын шатны шүүх, Цагдаагийн байгууллага шуурхай шийдвэрлэх, шийдвэрийн үндэслэлээ маргаанд оролцогч талууд, олон нийтэд ойлгомжтой тайлбарлах;

6.2 Жагсаал, цуглааныг хязгаарлах аливаа арга хэмжээ нь зөвхөн зайлшгүй шаардлагатай, тохирсон байх бөгөөд нийтийн дэг журмыг сахих болон үндэсний аюулгүй байдал, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой байна. Жагсаалд оролцох эрхийг бүхэлд нь хориглох нь олон улсын хүний эрхийн хуульд нийцэхгүй бөгөөд арга хэмжээнүүд нь зайлшгүй шаардлагатай зорилгод хүрэх хамгийн бага нөлөөтэй байх зарчмыг баримтлах;

6.3 Төрийн байгууллагууд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хүндэтгэж, оролцогчдын аюулгүй байдлыг хангах, зохих хамгаалалтыг үзүүлэх үүрэгтэй бөгөөд эсрэг жагсаалуудыг хүчирхийлэлд хүргэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Комисс нь сонгуулийн үйл явцад байнгын хяналт тавьж, хүний эрхийн зөрчлийг баримтжуулан дүн шинжилгээ хийж, иргэдийн гомдол, мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага шуурхай шийдвэрлэхэд хамтран ажиллана. Олон нийтийн дунд үл ойлголцол, зөрчил, маргаан, үүссэн тохиолдолд асуудлыг яриа хэлэлцээр, зөвшилцлийн аргаар шийдвэрлэхэд идэвхтэй оролцоно.



## **НЭР ДЭВШИГЧ, УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЛҮҮДЭД ӨГӨХ САНАМЖ**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд тойрогт 19 нам, хоёр эвслээс болон бие даан нэр дэвшигч 996, жагсаалтаар 15 нам, хоёр эвслээс 370, нийт 1,336 нэр дэвшигч оролцож байна.

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хугацаанд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой дараах зөрчил, дутагдлууд гарсныг холбогдох байгууллагуудын тайлан, мэдээлэлд дурдсан байна. Үүнд:

2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн хүрээнд Цагдаагийн байгууллагад нийт 2,569 гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл ирсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 182, зөрчлийн шинжтэй 2,387 гомдол, мэдээлэл ирсэн. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс “Бэлэн мөнгө, эд зүйл тараасан” гэх 27, “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан” гэх 63, “Самбар алдсан” гэх 47, “Сурталчилгааны зураг, самбар, зурагт хуудас болон бусад сурталчилгааны материалыг санаатайгаар устгах, бохирдуулсан” гэх 2, “Хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан” гэх 17, “Сонгуулийн хэсгийн хорооны байр, бусад газарт танхайрсан” гэх 3, бусад 23 гэсэн тоон үзүүлэлттэй байна. Үүнээс хамгийн их гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл нь “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан” гэх буюу Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд заасан “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл нь нийт гомдол, мэдээллийн 35 орчим хувийг эзэлж байна.

Зөрчлийн шинжтэй 2,387 гомдол мэдээллээс “Хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан” гэх Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18.1-д заасан “Сонгуулийн хуулийг зөрчих” зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл нь 1,000 буюу нийт гомдол, мэдээллийн 42 орчим хувийг эзэлж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллээс үзвэл 2020 оны сонгуулийн хүрээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16.1-д заасан сонгогчдын саналыг татах зорилгоор “бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн” зөрчлөөр 2 хэрэг, 16.2-т заасан сонгогчдын саналыг татах зорилгоор

“нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн” зөрчлөөр 4 хэрэг, 16.4-т заасан сонгогчдын саналыг татах зорилгоор “ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн” зөрчлөөр 4 нийт 10 хэргийг шийдвэрлэсэн байна.

“Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ-аас хийсэн Улс төр дэх залуучуудад болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээлт судалгааны тайланд “Олон нийтээс улс төрчдийн гэр бүлд тавих шалгуур хүйсийн хувьд харилцан адилгүй байна. Гэр бүл цуцлуулсан, гэр бүлийн хүн нь гадаадын иргэн байх зэрэг ижилхэн нөхцөлд эмэгтэй улс төрчдөд эрэгтэйчүүдээс илүү хатуу шалгуур тавьж, ялгавартай ханддаг” гэж дүгнэсэн.

Үндэсний аудитын газрын УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан мэдээнээс үзвэл 2020 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нийт 606 нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа 469 нэр дэвшигчид ирүүлсэн буюу 137 нэр дэвшигч тайлангаа ирүүлээгүй зөрчил гаргажээ. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/23 дугаар тушаалаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 360.4 сая төгрөгөөс 775.5 сая төгрөгийн хооронд тогтоосон зардлын дээд хэмжээг 2 нэр дэвшигч нийт 48.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-д “ ... нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 436, хугацаа хоцроосон 33, тайлангаа ирүүлээгүй 137 нэр дэвшигч байна. Нийт 469 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлснээс аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан 427, баталгаажуулаагүй 42 тайлангаас 36 тайлан орлого, зарлага тайлагнаагүй “х” тайлан байна.

“Хэвлэлийн Хүрээлэн” НҮТББ-аас хийсэн 2020 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааны мониторингийн дүнгээр сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаанд буюу 2020 оны 6

дугаар сарын 2-22-ны өдрүүдэд фейсбүүкээр түгээсэн, сонгуультай холбоотой мэдээллийн 80 гаруй хувь нь төрөл бүрийн ил, далд ухуулга, сурталчилгаа болон өрөөсгөл, дэгсдүүлсэн, бүрэн бус, гуйвуулсан мэдээлэл байснаас зөвхөн 20 орчим хувь нь нам, нэр дэвшигчийн нэр, лого бүхий хууль ёсны сурталчилгаа, үлдэж буй дийлэнх хэсэг нь ухуулга байх магадлалтай хувь хүний үзэл бодол, мөн бусдын үзэл бодлыг баримт мэт харагдуулах, нэр дэвшигч, нам, эвслийн нэр хүнд, итгэл үнэмшлийг унагах, дөвийлгөх, буруутгах, эргэлзээ төрүүлэх зорилго бүхий мэдээлэл байсан гэж дүгнэсэн.

Комисс 2012, 2016 болон 2020 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үеэр олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан сонгуулийн эрх бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэд мониторинг хийж ирсэн бөгөөд мониторингийн явц, үр дүнгээс үзэхэд зарим санал авах, ухуулах байр тэргэнцэртэй иргэн саадгүй нэвтрэхэд хүндрэлтэй буюу байрны орц, гарц, налуу зам стандартад нийцээгүй огцом шаттай, налуу зам болон бусад зай талбайн хүртээмжгүй байдлаас тэргэнцэртэй иргэн орох боломжгүй байна. Харааны бэрхшээлтэй иргэдэд ялангуяа сул хараатай иргэдэд зориулан гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, мэдээллийн самбарын үсгийн фонтыг 16-аас доошгүй хэмжээгээр хэвлэн байрлуулах, түүнчлэн сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан харилцах самбар байршуулж, түүнд түгээмэл хэрэглэх үг, яриаг ойлгомжтой байдлаар зургаар дүрслэн үзүүлэх боломжтой байхаар зохион байгуулах нь чухал байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд намын дарга, ухуулагчаар ажиллаж байсан иргэний амь нас эрсэдсэн, архи, согтууруулах ундаа хэрэглэсэн байж болзошгүй талаарх албан бус мэдээллүүд байна.

Иймд Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигч, улс төрийн нам, эвслүүд болон түүний сонгууль эрхэлсэн байгууллага нь сонгуулийн сурталчилгаа хийх, шударгаар өрсөлдөхтэй холбоотой үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэхэд анхаарч дараах санамжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Сонгуулийн сурталчилгаа хийхдээ хууль ёс, шударга ёсыг баримтлан бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэх;

2. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид үзэн ядалт, хүчирхийлэлд уриалахгүй, бусдын нэр төрийг гутаах зорилготой худал мэдээлэл тараахгүй байх;

3. Эмэгтэй улс төрчийг харлуулахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг хориглох, хүйсийн хувьд гутаан доромжлохгүй байх, улс төрийн ардчилсан өрсөлдөөнд аливаа хүйст хүндэтгэлтэй хандах;

4. Иргэдийг санал өгүүлэх зорилгоор санал авах байр луу зөөвөрлөхийг зогсоох, сонгуульд оролцохоос татгалзах, нэр дэвшигчдийг багаар нь сонгуулах зэргээр сонгогчийн сонгох эрхэд нөлөөлөх, хүний үзэл бодлыг үл хүндэтгэх, төөрөгдүүлэх агуулга бүхий сурталчилгаа явуулахгүй байх;

5. Нэр дэвшигч өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор мөнгө, эд зүйл тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөх, амлах, ажлын байранд зуучлах, ажилд оруулах, амлалт өгөх зэрэг хууль зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;

6. Хиймэл оюун, олон нийтийн сүлжээ ашиглан үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд уриалсан илэрхийлэл, хүний нэр төр, эрхэм чанарыг гутаах зорилготой худал мэдээлэл бүхий контент бүтээхэд сонгуулийн сурталчилгаа явуулж байгаа, технологи хөгжүүлж байгаа хүн, хуулийн этгээд оролцохгүй байх;

7. Ухуулах байр, сонгуулийн сурталчилгааны материал, хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, баривчлагдсан, цагдан хоригдсон хүнд тохиромжтой байдлаар бэлтгэх, мэдээллийн хүртээмжийг хангасан байх;

8. Хүний хувийн мэдээлэл болох иргэдийн регистрийн дугаар, гэрийн хаяг, холбоо барих мэдээллийг цуглуулах, хууль бусаар ашиглахгүй байх;

9. Сонгуулийн сурталчилгааны хугацаанд төгсөлтийн, ургийн уулзалт зохион байгуулах нэрээр сонгогчдод нөлөөлөх, санал авах зорилгоор архи, согтууруулах ундааг хэрэглүүлэхгүй байх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахад онцгой анхаарах;

10. Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй, үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө ялгаварлан гадуурхахгүй байх, хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх;

11. Ард түмнийг талцуулах, хуваагдал үүсгэх, үндэсний эв нэгдлийг бусниулах зэргээр хэт улс төржихгүй байх, үзэл бодол, бодлогын хувьд шударга ёсны зарчмаар өрсөлдөх.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч, улс төрийн нам, эвслүүд сонгуулийн үйл ажиллагаандаа хүний эрхийн зарчим, хэм хэмжээг мөрдлөг болгон дээрх санамжийг өөрийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүнд танилцуулан хэрэгжүүлж ажиллахыг хүсье.

## МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС